



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 10


Улаанбаатар хот

Сургалтын нэг кредитийн төлбөр тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн төлбөрийг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.
2. Магистрантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.5 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
3. Докторантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
4. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.2 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
5. ШУТИС-д хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
6. ШУТИС-д суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тооцохдоо энэхүү тогтоолын 1-5 дахь заалтуудыг баримталсугай.
7. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Шинжлэх ухаан технологийн ахлах сургууль, ШУТИС-Коосен технологийн коллежийн 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь ТИС лицей сургуулийн сургалтын төлбөрийг 1,200,000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгөөр тогтоосугай.
8. Сургалтын нэг кредитийн төлбөрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ШУТИС-ийн 2018 оны төсөвт шаардлагатай тодотголыг хийж, Удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэхийг захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ нарт даалгасугай.

ДАРГА  Б.ГАНБАТ



ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 18 -ны өдрийн 10 тоот тогтоолын хавсралт

ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөр (төгрөгөөр)



д/д	Сургуулийн нэр	Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ	
		2018 онд элсэн суралцагчид	2018 оноос өмнө элсэн суралцагчид
1	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	74,900	73,000
2	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	78,900	76,900
3	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
4	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	67,600	65,900
5	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
6	МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	78,900	76,900
7	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	74,900	73,000
8	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	68,900	67,200
9	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ	76,700	74,700
10	ГАДААД ХЭЛНИЙ ИНСТИТУТ	65,600	64,000
	Дундаж	73,620	71,760